

**ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗҮҮДЭЭР 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД
НЭВТРҮҮЛСЭН ҮНДЭСНИЙ ТҮҮХ, СОЁЛ УЛАМЖЛАЛ, ТАНИН МЭДЭХҮЙН
НЭВТРҮҮЛГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮГНЭЛТ**

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-аар Монгол улс болон Улаанбаатар хотод хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 200 цагаас багагүй үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэг хүлээлгэдэг. Зохицуулах хорооноос телевизүүдийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингийн тайланд үндэслэн улирал тутам дээрх үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гарган ажиллаж байна.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал 2023 оны 1 дүгээр улирлын дүнгээр дараах байдалтай байна.

**Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн үндэсний түүх, соёл, уламжлалын
нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал**

(2023 оны 1-3 дугаар сар)

Хүснэгт 1

Телевизийн нэр	2023 он 1 сар	2023 он 2 сар	2023 он 3 сар	2023 оны 1-р улирал
TB8	25:57:34	28:13:00	31:11:27	85:22:01
NTV	16:38:25	28:49:08	28:28:46	73:56:19
Боловсрол суваг	20:52:36	25:10:54	20:22:12	66:25:42
Central	21:14:01	19:22:25	25:06:13	65:42:39
Сүлд	20:34:58	24:43:56	14:48:42	60:07:36
TB9	21:23:43	20:54:22	15:06:11	57:24:16
Монгол	18:29:41	21:22:19	16:40:40	56:32:40
Малчин	11:56:39	19:07:22	23:39:18	54:43:19
Стар	7:04:37	19:22:09	21:10:53	47:37:39
TM	8:39:17	17:14:34	18:38:49	44:32:40
TenGer	11:09:41	9:40:04	11:47:32	32:37:17
SBN	4:58:47	7:59:58	14:25:32	27:24:17
ETV	7:07:23	12:51:19	01:34:59	21:33:41
25-р суваг	2:03:58	14:53:25	00:11:12	17:08:35
UBS	1:51:05	6:52:17	0:00:00	8:43:22
C1	1:48:28	4:20:19	0:00:00	6:08:47
TB5	0:00:00	1:28:07	00:47:30	2:15:37
Ийгл ньюс	0:00:00	0:48:03	0:00:00	0:48:03
Нийт	175:53:19	255:00:41	212:48:29	643:42:29

Өргөн нэвтрүүлгийн 18 телевизийн 2023 оны 1 дүгээр улиралд бэлтгэн нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн нийт цагийг авч үзэхэд 50% нь шаардлага хангах хэмжээнд хүрсэн, тухайлбал TB8, NTV, Боловсрол суваг, Central, Сүлд, TB9, Монгол, Малчин телевизүүд үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг 50 цагаас дээш нэвтрүүлсэн, бусад улирлуудад дунджаар энэ цагаа бууруулахгүй байвал жилд нэвтрүүлэх шаардлага бүрэн хангахаар байна. Харин Стар, TM телевизийн тухайд 1 улиралд 50 цаг хүрээгүй ч бусад улиралд цагаа төлөвлөж ажиллавал мөн хангах боломжтой гэж дүгнэхээр байна.

Ийгл нь юс, ТВ5, С1, UBS телевизүүд бүтэн улирлын турш 10 хүрэхгүй цаг нэвтрүүлсэн явцтай байгааг цаашид нэмэгдүүлэхгүй бол жилийн эцсийн дүнгээр шаардлага хангах хэмжээнд хүрэхгүй гэж дүгнэхээр байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр 2023 оны 1 дүгээр улиралд нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан авч үзье.

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр 2023 оны 1 дүгээр улиралд нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагийг 2022 оны мөн үетэй харьцуулсан байдал

Хүснэгт 2

Телевизийн нэр	2022 он 1 сар	2022 он 2 сар	2022 он 3 сар	2022 он 1-р улирал	2023 он 1 сар	2023 он 2 сар	2023 он 3 сар	2023 он 1-р улирал
ТВ8	19:46:48	15:27:36	16:37:00	51:51:24	25:57:34	28:13:00	31:11:27	85:22:01
NTV	01:48:26	08:02:31	03:51:52	13:42:49	16:38:25	28:49:08	28:28:46	73:56:19
Боловсрол суваг	18:12:43	14:19:51	36:18:47	68:51:21	20:52:36	25:10:54	20:22:12	66:25:42
Central	36:36:57	28:56:36	39:39:55	105:13:28	21:14:01	19:22:25	25:06:13	65:42:39
Сүлд	17:16:35	15:57:36	21:48:06	55:02:17	20:34:58	24:43:56	14:48:42	60:07:36
ТВ9	05:13:39	02:47:51	06:30:03	14:31:33	21:23:43	20:54:22	15:06:11	57:24:16
Монгол	11:57:05	23:42:17	28:31:00	64:10:22	18:29:41	21:22:19	16:40:40	56:32:40
Малчин	08:27:42	09:55:15	06:32:03	24:55:00	11:56:39	19:07:22	23:39:18	54:43:19
Стар	09:38:05	07:31:12	00:31:28	17:40:45	7:04:37	19:22:09	21:10:53	47:37:39
ТМ	09:24:55	12:45:55	04:50:13	27:01:03	8:39:17	17:14:34	18:38:49	44:32:40
TenGer	00:59:26	00:00:00	01:59:03	2:58:29	11:09:41	9:40:04	11:47:32	32:37:17
SBN	05:04:02	10:12:03	08:18:04	23:34:09	4:58:47	7:59:58	14:25:32	27:24:17
ETV	01:57:39	11:12:23	00:54:58	14:05:00	7:07:23	12:51:19	01:34:59	21:33:41
25-р суваг	1:08:28	1:56:09	0:58:03	4:02:40	2:03:58	14:53:25	00:11:12	17:08:35
UBS	09:15:31	04:52:32	03:32:09	17:40:12	1:51:05	6:52:17	0:00:00	8:43:22
С1	00:00:00	04:01:02	00:00:00	4:01:02	1:48:28	4:20:19	0:00:00	6:08:47
ТВ5	00:30:15	03:51:47	05:01:18	9:23:20	0:00:00	1:28:07	00:47:30	2:15:37
Ийгл нь юс	00:00:00	02:50:19	00:00:00	2:50:19	0:00:00	0:48:03	0:00:00	0:48:03
Бүгд	157:18:16	178:22:55	185:54:02	521:35:13	201:50:53	283:13:41	243:59:56	729:04:30


Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевизээр үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг 2022 оны 1 дүгээр улиралд 521 цаг, 2023 оны 1 дүгээр улиралд 729 цаг тус тус нэвтрүүлжээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 39%-аар өссөн үзүүлэлттэй байна. NTV, ТВ9, ТВ8, Малчин, Стар телевизүүд үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үүргээ хэрэгжүүлэхэд анхаарч 2023 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30-60 цагаар илүү нэвтрүүлж, хамгийн өндөр хувийн өсөлт үзүүлсэн байна.

2022 оны эхний хагаст үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүргийн хэрэгжилт 27.8 %-тай буюу зөвхөн 5 телевиз шаардлага хангах хэмжээнд нэвтрүүлсэн бол 2023 оны 1 дүгээр улиралд 55.5 % болж өссөн нийт 10 телевиз шаардлага хангасан болон шаардлага хангах боломжтой хэмжээнд хүрсэн байна.

Үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал

(2022 оны 1-3 дугаар сар болон 2023 оны 1-3 дугаар сар)


График 1



2023 оны 1 дүгээр улирлын дүнг сараар нь авч өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд сар тутамд мөн 44-104 цагаар нэмэгдсэн сард дунджаар 69 цагаар өссөн үзүүлэлттэй байна.

Үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлэлтэд орсон өөрчлөлтийн байдал

График 2



Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн үзүүлэлтийг хугацаагаар нь бүлэглэн дээрх графикт үзүүллээ.

2022 оны 1 дүгээр улирлын дүнг 2023 оны 1 дүгээр улирлын дүнтэй харьцуулахад хэрхэн өссөн өсөлтийг дээрх графикаас харж болно. Хэдийгээр Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн 50 хувь нь “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-аар

хүлээсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлэх үүргээ бүрэн биелүүлээгүй ч нийт дүнгээрээ өссөн үзүүлэлттэй байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдаж, хуульд нийцүүлэн батлан гаргасан баримт бичгүүдийн хүрээнд Зохицуулах хорооноос 2022 онд телевизүүдэд хяналт, мониторингийн ажлыг хийж гүйцэтгэн, 12 телевизэд үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагийг нэмэгдүүлж ажиллах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч, үүрэг даалгаврын биелэлтийн байдлыг хянан авч үзсэний үндсэн дээр шаардлага биелүүлээгүй 10 телевизэд анхааруулга хүргүүлэх байдлаар хуульд заасан шат дараатай арга хэмжээг авч ажиллаж байна.

Мониторингоор үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цагт үндэсний уламжлалт, түүх, соёлын өвийг тайлбарлан таниулсан баримтат бүтээл, нэвтрүүлгийг тооцдог юм.

--oOo--